

Бид АТОМыг удирдаж сурсан уу?

(АЦС = ЦӨМИЙН АЮУЛ)

Саяхны ТВ25-аар гарсан “Цөмийн хаягдал– Дуусаагүй Яриа” нэвтрүүлгээр “Хүн төрөлхтөн атомыг удирддаг болчихсон” гэж эрх мэдэлтнүүд ам булаалдан ярьж, Фукушимагийн ослыг Япончуудын арчаагүй байдлаар тайлбарлаж байсан.

Зөвхөн “арчаа сайтай” Монголчууд л АЦС барьвал осол аюулгүй амар мэнд байх нь дээгүүр хэдэд тодорхой ажээ.

Гэтэл Японы цөмийн ослын дараа атомын өмнө хүчин мөхсөө мэдэрсэн дэлхийн улс орнууд АЦС-уудаа хаах шийдвэр гаргаж эхэллээ. Итали улс АЦС-уудаа сэргээн ашиглах асуудлаа жилээр хойшлуулж, Швейцарь улс АЦС-аа аажмаар хааж, 2034 гэхэд атомгүй улс орон болохоо мэдэгдсэн бол Германчууд 6 сарын 6-нд ард түмнээсээ санал хурааж асуудлыг шийдэх болсон ба АЦС-уудаа хаана гэдэгт итгэлтэй байна.

Хэрэв та Монголын эрх баригчдын үгэнд эргэлзэж байгаа бол УБЦТК ХК-ний зөвлөх инженер Т. Минжүүр гуайн ирүүлсэн мэдээллийг үзээрэй.

Цаг заваа гаргаж мэдээлэл бэлтгэсэн Минжүүр гуайдаа баярлалаа.

Хүндэтгэсэн,
Амарлин
<http://golomt.org>

АЦС-ыг ажиллуулаад эзэнгүй орхиж болох цаг ирчихсэн мэтээр ярьдаг болсон нь үнэнд хэр нийцэж байгаа бол ???



Цацраг идэвхит бодисын үйлдвэрлэл ба хэрэглээний явцад нийтийг хамарсан цацрагын хордлого ба сүйрэлд хүргэж болзошгүй нөхцлүүд жил бүр л олон удаа үүссээр байдаг ажээ. Эдгээр нөхцлүүдийн шалтгаан нь маш олон янз байна. Тэдгээр шалтгааныг урьдчилан илрүүлж, илэрсэн болон хүнд нөхцөл үүссэн тохиолдол бүрд цаг алдалгүйгээр зөв арга хэмжээ авч байгаа нь л биднийг аварч байдаг ажээ.

Жишээ болгож, 2003, 2004 онуудад гарсан бөгөөд ноцтой хүнд үр дагаварт хүргэж болзошгүй байсан тохиолдлуудаас танилцуулъя.

<http://www.dront.ru/old/defense/aes/kalendarAES.html>

Бусад онуудад тохиолдож байсан хүнд үр дагавартай тохиолдлуудыг энд дурьдахыг хичээсэнгүй. Цацраг идэвхит бодисын үйлдвэрлэл ба хэрэглээ өнөөдөр нийтэд хэр аюулгүй явагдаж байна вэ гэдэг талаар та жаахан бодож үзээрэй.

2003 он.

4-р сарын 1. ОХУ. Саратов муж. Балаковын АЦС. Хөргөлтийн гол насосуудын нэг нь зогссон тул станцийн төхөөрөмжүүдийн 1-р багцийг аваарийн журамаар зогсоосон.

4-р сарын 10. Унгар. Пакшийн АЦС. Дулаан ялгаруулагч багц (цөмийн түлш) хэт халж гэмтсэнээс радио идэвхит хий агаарт цацагдсан.

4-р сарын 16. АНУ. Иллинойс. «Квад-Сайтс» АЦС. Реакторын хөргөлтийн системийн хэсэгт юүлэх хаалт санамсаргүй нээгдсэн.

4-р сарын 24. ОХУ. Челябинск муж. Цөмийн «Маяк» цогцолбор. Радио идэвхит тоос

цацагдсан.

6-р сарын 1. Бельги. «Тианж» АЦС. Төлөвлөгөөт сорилт, туршилтын үед ажилтны буруу үйлдлээс шалтгаалж цахилгааны аккумуляторууд нь гэмтсэн.

6-р сарын 26. Гүрж, Садахло. Өндөр баяжуулсан уран хадгалж, нууцаар хил давуулах оролдлого хийсэн хүн баригдсан.

8-р сарын 5. АНУ, Лос-Аламос. Үндэсний лаборатори. Плутони боловсруулах хэсэгт савлах ажлыг буруу гүйцэтгэснээс ажилчид нь цацраг туяанд хордсон.

10-р сарын 28. Их британи. «Хейшем» АЦС. Хөргөлтийн ус дамжуулах хоолой цоорсоноос турбины заал нь усанд автаж станцийг бүрэн зогсоосон.

11-р сарын 10. АНУ, Нью-Гемпшир. «Сибрук» АЦС. Турбины зааланд нь устөрөгч хуримтлагдаж тэсрэх хэмжээнд хүрсэн байсныг илрүүлсэн.

11-р сарын 12. ОХУ, Кольскийн булан. Далайн экологийн хяналтын байгууллага далайн 3м гүнд цөмийн түлштэй савх гээснийг илрүүлсэн.

2004 он.

2-р сарын 6. Франц. «Катенном-3» АЦС. Түлш солих үедээ өмнө нь түлшний нэг багцийг буруу байрлалд суурилуулсаныг илрүүлсэн.

2-р сарын 8. Герман. «Библис» АЦС. «Библис-В» станцийг «Библис-А» станцаас аваарийн горимоор цахилгаанаар тэжээх үед туслах системийн зарим хэсгүүд нь ажиллаагүй.

4-р сарын 25. Герман. «Филиппсбург-1» АЦС. Төлөвлөгөөт сорилт шалгалт явуулах үед цацраг идэвхит ус алдагдсан.

5-р сарын 8. Герман. «Филипповичем-1» АЦС. Аваарийн дизель генератор гэмтэлтэй байгааг илрүүлсэн.

5-р сарын 12. АНУ, Нью-Мехико. Лос-Аламос дэх Үндэсний лабораторийн цөмийн цэнэгийн үйлдвэрлэлийн ба хаягдал хадгалах байрны дэргэд гал түймэр гарсан.

5-р сарын 16. Франц. Каттенном дэх АЦС. Турбины заал дэх кабелийн шуудуунд гал гарсан. Шатаж байгаа кабелиудад хүрэхийн тулд гал унтраагч нар ханыг нураахад хүрсэн.

6-р сарын 10. Герман. «Брунсбюттель» АЦС. Борын хүчлийн хяналтын систем дэх борын хүчлийн концентрацийн хувь өөрчлөгдсөн.

6-р сарын 18. АНУ, Вермонт. «Янки-Роу» АЦС. Гол трансформатор луу явсан цахилгаан кабель шатаж, турбин зааланд гал түймэр үүссэн.

9-р сарын 10. ОХУ, Бунге-ийн Газар арал. Цөмийн түлшний хаягдал тээвэрлэж байсан нисдэг тэрэг цаг уурын хүнд нөхцлөөс шалтгаалж цааш тээвэрлэх боломжгүй болж түүнийгээ замдаа хаяж буцсан.

10-р сарын 5. Франц. Германы Лингенаас 4,5т баяжуулсан ураныг Блайарисын АЦС руу тээвэрлэж явсан ачааны машиныг Парижийн ойролцоо өөр машин мөргөсөн.

12-р сарын 20. Чех. «Темелин» АЦС. Хөргөлтийн систем дэх цооролтоор станцийн талбайд 20тн цацраг идэвхит ус алдагдсан.

12-р сарын 26. Энэтхэг. «Мадрас-2» АЦС. Газар хөдөлж далайд цунами үүссэнээс станцийн талбай далайн усанд автаж, реакторыг зогсоосон.

Зөвлөх инженер Т.Минжүүр (УБЦТС ХК)